



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/17

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тушаалын "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 2 дугаар хавсралтын 3.1.2 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон Улсын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан байгууллагын харьяатай 17 ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 510,000 (таван зуун арван мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай
3. 2. Дээрх зардалд шээрдагдах 510,000 (таван зуун арван мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР


ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ШИНЭБАЯР



Баянтал сум
Х.Ариунгуа

Засаг даргын Тамгын газрын даргын
2024 оны 10 сарын 08 өдрийн
А/17 дугаар тушаалын хавсралт



Төсвийн задаргаа

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Цэвэр сүү	ш	17	5,500	93,000
2	Тэмдэглэлийн дэвтэр	ш	17	3,000	51,000
3	Халуун хэмжигчтэй аяга	ш	17	15,000	255,000
4	Цай	ш	17	4,500	76,500
5	Бэлгийн уут	ш	17	2,000	34,000
Нийт					510,000



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/18

Баянтал сум

Байгууллагын ёс зүйн дэд хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга:

Хууль эрх зүй хариуцсан

мэргэжилтэн

Ёс зүйн дэд хорооны гишүүн:

ЗДТГ-ын жижүүр

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:


Нийгмийн бодлогын

мэргэжилтэн

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулахыг Ёс зүйн дэд хорооны дарга гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэх байгуулах тухай” 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ШИНЭБАЯР